



МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

**ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭНИЙ ШОШГЫН ХЭЛБЭР ХЭМЖЭЭ, ЗАГВАРТ
ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА
MNS.....**

Албан хэвлэл

**СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР
УЛААНБААТАР ХОТ
2020 ОН**

Монгол улсын стандарт

Ангиллын код:

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭНИЙ ШОШГЫН ХЭЛБЭР ХЭМЖЭЭ, ЗАГВАРТ ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА	MNS
GENERAL REQUIREMENTS FOR THE FORM AND SIZE OF THE ENERGY COMSUMPTION LABEL	

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 20...оны...сарын...өдрийн...дүгээр тушаалаар батлав.

Энэхүү стандарт батлагдсан өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ:

1.1

Энэхүү стандарт нь эрчим хүчний хэрэглээний хураангуй мэдээллийг агуулсан баримт буюу шошго, түүний хэлбэр хэмжээ, загвар, өнгөний кодыг тодорхойлно.

1.2

Энэхүү стандартыг эрчим хүчээр ажилладаг машин, тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний цахилгаан бараанд олгох шошгыг хэвлэх, олшруулахад хэрэглэнэ.

2 Нэр томъёоны тодорхойлолт

Энэхүү стандартад дурдсан дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

ТАЙЛБАР: Эрчим хүчний хэрэглээний шошготой холбогдох аливаа харилцаа нь Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 9.1.9-д заасан журмаар зохицуулагдана.

2.1

Эрчим хүчний хэрэглээний шошго

Эрчим хүчээр ажилладаг машин, тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний цахилгаан барааны эрчим хүчний хэрэглээний хураангуй мэдээллийг агуулсан, үр ашигтай эсэхийг тодорхойлсон хэвлэмэл баримт байна

2.2

Харьцуулсан шошго

Эрчим хүчний хэрэглээний үзүүлэлтийг тооцоолон, үр ашгийн түвшнээр зэрэглэлийг тодорхойлсон хэвлэмэл баримт байна

2.3

Нотолсон шошго

Эрчим хүчний үр ашигтай эсэх нь холбогдох норм, стандартаар тодорхойлогдсон хэвлэмэл баримт байна

3 Шошгод тавих шаардлага

3.1 Эрчим хүчээр ажилладаг машин, тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний цахилгаан бараанд олгох шошгын хэлбэр хэмжээ, загварыг Стандартчиллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр баталж, эрх бүхий байгууллагад зохих журмын дагуу бүртгүүлнэ.

3.2 “Эрчим хүчний хэрэглээний шошгын хэлбэр хэмжээ, загварт тавигдах ерөнхий шаардлага” стандартыг эзэмшигч нь Стандартчиллын төв байгууллага байна.

3.3 Эрчим хүчний хэрэглээний шошгын загварыг эзэмшигч нь Эрчим хүчний зохицуулах хороо байна.

3.4 Шошго нь өнгө дүрсний хослол сайтай, суурь өнгөнөөс тод ялгарч, үндэсний хэв шинжийг агуулан дүрслэгдсэн, аливаа тохиолдолд арилахгүй байвал зохино.

3.5 Үйлдвэрлэсэн, импортолсон эрчим хүчээр ажилладаг машин, тоног төхөөрөмж, ахуйн хэрэглээний цахилгаан бараанд олгох шошгыг энэхүү стандартын дагуу хэвлэж хэрэглэнэ.

3.6 Эрчим хүчний хэрэглээний шошгыг гуравдагч этгээдэд шилжүүлэх, дамжуулах, шошго аваагүй өөр бүтээгдэхүүнд ашиглаж болохгүй.

3.7 Эрчим хүчний хэрэглээний шошгыг хэрэглэгчдийг төөрөгдүүлсэн, худал зар сурталчилгаа болон хууль бус үйл ажиллагаанд ашиглаж болохгүй.

3.8 Шошго эзэмшигчид энэхүү стандартыг мөрдөж буй эсэхэд хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хяналт тавьж ажиллана.

4 Шошгын хэлбэр хэмжээ, загвар

4.1 шошгод агуулагдах үндэсний хэв шинжийг агуулсан тэмдгийн үлгэрчилсэн загвар нь 1 дүгээр зурагт, түүний хэмжээний харьцаа нь 2 дугаар зурагт дурдсаны дагуу миллиметрээр дүрслэгдэнэ.

4.1.1 Тэмдгийн өнгөний формат CMYK, дэвсгэр өнгө цагаан бөгөөд эрчим хүчний хэрэглээний зэрэглэл нь үр ашигтайгаас хамааран өөр өөр өнгөөр илэрхийлэгдэнэ.



RGB 0, 102, 51 эсхүл #006633

RGB 51, 204, 51 эсхүл #33cc33


RGB 255, 204, 0 эсхүл #ffcc00

RGB 255, 102, 51 эсхүл #ff6633

RGB 255, 51, 51 эсхүл #ff3333

1 дүгээр зураг- Тэмдгийн загвар, өнгөний үлгэрчилсэн загвар, өнгөний код.

4.1.2 Тэмдэг нь 30x60мм хэмжээнээс хэтрэхгүй бөгөөд хэрэв том, эсхүл жижиг хэмжээгээр хэвлэх бол хэмжээний харьцаа алдагдахгүй байна.



2 дугаар зураг- Тэмдгийн үлгэрчилсэн загвар, түүний хэмжээс.


4.2 Харьцуулсан шошго

4.2.1 Харьцуулсан шошгын хэлбэрийн үлгэрчилсэн загвар 3 дугаар зурагт, түүний хэмжээний харьцаа нь 4 дүгээр зурагт дурдсаны дагуу миллиметрээр хэмжигдэнэ. Энэхүү стандартаар заасан харьцуулсан шошгын харьцаа нь түүнийг ашиглагчдад болон хэрэглэгчдэд үлгэрчилсэн загвар болох, зөв буулгах суурь үндэслэл болно.

I. ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭРЭГЛЭЭНИЙ ШОШГО II. /Шошгын ангилал/ III. Бүтээгдэхүүний нэр: IV. Дугаар: хх-0хх/20хх		I. Arial bold 12pt, uppercase, 100% хар. II. Arial 10 pt, 100% хар. III. Arial bold 12 pt, 100% хар. IV. Arial 10 pt, 100% хар.
V. Бүтээгдэхүүн үйлдвэрлэгчийн нэр: VI. Бүтээгдэхүүний загвар:	VII. ЛОГО	V. Arial bold 12 pt, 100% хар. VI. Arial bold 12 pt, 100% хар. VII. Үйлдвэрлэгчийн лого.
VIII. 	IX. 	VIII. Эрчим хүчний хэрэглээний зэрэглэл. IX. Зэрэглэлийн өнгөтэй ижил дэвсгэр өнгө. X. Arial bold 46 pt, 100% цагаан.
XI. Эрчим хүчний зарцуулалт (кВт.ц/жил):	XII. 000	XI. Arial 12 pt, 100% хар. XII. Arial bold 16 pt, 100% хар.
XI. Чадал (кВт):	XII. 000	
XI. Техникийн үзүүлэлт (нэгж):	XII. 000	
XI. Техникийн үзүүлэлт (нэгж):	XII. 000	
XI. Байгаль орчны үзүүлэлт (нэгж):	XII. 000	
XIII. Шошго олгосон эрх бүхий байгууллагын нэр:	XIV. ЛОГО	XIII. Arial bold 12 pt, uppercase, 100% хар. XIV. Шошго олгогчийн лого.
XV. Монгол улсын Засгийн газрын 20 .. оны ... дугаар тогтоолоор баталсан журмын дагуу олгов.	XVI. QR КОД	XV. Arial italic 10 pt, 100% хар. XVI. Цахим дэлгэрэнгүй мэдээлэл.

3 дугаар зураг- Харьцуулсан шошгын хэлбэрийн үлгэрчилсэн загвар


4.2.2 Харьцуулсан шошго нь 160х90мм хэмжээнээс хэтрэхгүй бөгөөд хэрэв том, эсхүл жижиг хэмжээгээр хэвлэх бол хэмжээний харьцаа алдагдахгүй байна.



4 дүгээр зураг- Харьцуулсан шошгын хэмжээний үлгэрчилсэн загвар

4.3 Нотолсон шошго


4.3.1 Нотолсон шошгын хэлбэрийн үлгэрчилсэн загвар 5 дугаар зурагт, түүний хэмжээний харьцаа нь 6 дугаар зурагт дурдсаны дагуу миллиметрээр хэмжигдэнэ. Энэхүү стандартаар заасан нотолсон шошгын харьцаа нь түүнийг ашиглагчдад болон хэрэглэгчдэд үлгэрчилсэн загвар болох, зөв буулгах суурь үндэслэл болно.



- I. Arial bold 12 pt, uppercase, 100% хар.
- II. Arial 10 pt, 100% хар.
- III. Arial bold 12 pt, 100% хар.
- IV. Arial 10 pt, 100% хар.
- V. Эрчим хүчний үр ашигтайг нотлох тэмдэг.
- VI. Эрчим хүчний үр ашгийн стандартын дугаар.
- VII. Цахим дэлгэрэнгүй мэдээлэл.

5 дугаар зураг- Нотолсон шошгын хэлбэрийн үлгэрчилсэн загвар

4.3.2 Нотолсон шошго нь 65х90мм хэмжээнээс хэтрэхгүй бөгөөд хэрэв том, эсхүл жижиг хэмжээгээр хэвлэх бол хэмжээний харьцаа алдагдахгүй байна.



6 дугаар зураг- Нотолсон шошгын хэмжээний үлгэрчилсэн загвар

ТӨГСӨВ.

Ашигласан материал

- Эрчим хүчний ангилал зэрэглэл тогтоох, шошгожуулах журмын төсөл;
- International study on energy labeling and MEPS – IEA 4E
http://www.clasponline.org/Tools/Tools/SL_Search/SL_SearchResults/SL%20Detail%20Page?m=5e5c2e4c-f853-4d4e-8efc-409319d22d44
- S&L Guidebook CLAPS
- <https://clasp.ngo/publications/s-l-guidebook-english-version>
- Lessons learned international energy labelling programs for strengthening the China Energy Label program https://eta.lbl.gov/sites/default/files/publications/7-363-17_zhou_final.pdf